



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/158/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Ш.Нурлан

Утас: 99422966 Цахим хаяг: nurlansh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>127,110,684.93</u>	<u>219,285,713.18</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	69,964,759.55	119,361,077.05
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	69,964,759.55	119,361,077.05
3121	Төгрөг	69,964,759.55	119,361,077.05
31211	Төрийн сангийн харилцах	69,964,759.55	119,361,077.05
35	БАРАА МАТЕРИАЛ	57,145,925.38	99,924,636.13
351	Түүхий эд материал	-	4,725,945.75
35110	Тусгай зориулалттай материал	-	4,725,945.75
354	Хангамжийн материал	49,432,925.38	86,826,490.38
35410	Бичиг хэргийн материал	721,970.00	97,500.00
35420	Аж ахуйн материал	36,791,095.38	53,935,389.38
35460	Хүнсний материал	11,919,860.00	32,793,601.00
35600	Мал амьтад	7,713,000.00	8,372,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,057,032,592.28</u>	<u>6,241,846,415.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,057,032,592.28	6,241,846,415.82
392	Биет хөрөнгө	6,007,375,073.93	6,192,473,545.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	723,595,298.88	5,889,395,298.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	(205,332,834.94)	(245,079,494.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	221,097,974.55	344,318,681.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(87,014,765.77)	(133,632,941.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	120,539,332.92	271,438,840.92

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39208	Хуримтлагдсан элэгдэл	(73,369,942.20)	(88,510,168.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	141,373,660.00	144,173,660.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,024,807.51)	(25,787,713.83)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	5,160,200,000.00	-
39217	Ном	25,311,158.00	36,157,382.25
393	Биет бус хөрөнгө	49,657,518.35	49,372,870.55
39301	Програм хангамж	1,973,239.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(573,720.65)	(858,368.45)
39303	Бусад биет бус хөрөнгө	48,258,000.00	48,258,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,184,143,277.21</u>	<u>6,461,132,129.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>15,472,894.00</u>	<u>8,208,100.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,472,894.00	8,208,100.00
413	Өглөг	15,472,894.00	8,208,100.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	13,130,474.00	-
4136	Бусад өглөг	2,342,420.00	8,208,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,342,420.00	8,208,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,168,670,383.21</u>	<u>6,452,924,029.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,168,670,383.21	6,452,924,029.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	679,906,375.91	679,906,375.91
51101	Өмч: - төрийн	679,906,375.91	679,906,375.91
512	Хуримтлагдсан үр дүн	4,896,351,601.56	5,180,605,247.35
51210	Өмнөх үеийн үр дүн	4,896,351,601.56	4,896,351,601.56
51220	Тайлант үеийн үр дүн	-	284,253,645.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	592,412,405.74	592,412,405.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,184,143,277.21</u>	<u>6,461,132,129.00</u>

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	СТ-2А
			/төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,424,961,320.00	2,932,152,212.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,316,841,920.00	269,335,312.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,316,841,920.00	269,335,312.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,903,648.00	4,748,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	753,000.00	4,412,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,150,648.00	336,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	5,314,138,272.00	241,749,422.25
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	800,000.00	22,837,389.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,108,119,400.00	2,662,816,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,654,250,300.00	2,435,714,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,654,250,300.00	2,435,714,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	453,869,100.00	227,102,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	453,869,100.00	227,102,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,139,269,536.23	2,647,898,566.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,139,269,536.23	2,647,898,566.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,094,415,486.23	2,600,158,342.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,230,726,868.53	1,862,584,187.12
210101	Үндсэн цалин	932,340,483.38	1,202,508,867.81
210102	Нэмэгдэл	261,261,474.65	604,481,469.31
210104	Урамшуулал	37,124,910.50	55,593,850.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,647,203.92	234,722,488.88
210201	Тэтгэврийн даатгал	105,951,996.48	161,155,646.30
210202	Тэтгэмжийн даатгал	12,479,311.09	18,940,814.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,067,673.36	9,569,875.65
210204	Ажилгүйдлийн даатгал	2,376,185.26	8,994,618.68
210205	Эрүүл мэндийн даатгал	23,772,037.73	36,061,534.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	456,888,974.00	213,279,026.00
210301	Гэрэл, цахилгаан	6,996,624.00	9,265,748.09
210302	Түлш, халаалт	449,892,350.00	204,013,277.91
2104	Хангамж, бараа материалын зардал	7,458,571.00	-
210408	Бараа материал акталсны зардал	7,458,571.00	-
2105	Нормативт зардал	99,082,616.00	86,917,405.00

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	99,082,616.00	86,917,405.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,903,100.00	34,337,499.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	753,000.00	11,745,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,150,100.00	22,592,299.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136,608,152.78	166,817,735.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,811,250.00	43,957,820.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,990,800.00	14,307,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	105,806,102.78	108,552,615.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,854,050.00	47,740,224.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,854,050.00	47,740,224.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,854,050.00	47,740,224.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>5,285,691,783.77</u>	<u>284,253,645.79</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>5,285,691,783.77</u>	<u>284,253,645.79</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,110,023,048.00</u>	<u>2,667,565,400.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,903,648.00	4,748,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,903,648.00	4,748,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,903,648.00	4,748,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	753,000.00	4,412,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,150,648.00	336,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,108,119,400.00	2,662,816,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,654,250,300.00	2,435,714,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,654,250,300.00	2,435,714,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	453,869,100.00	227,102,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	453,869,100.00	227,102,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,011,375,922.45</u>	<u>2,566,552,065.37</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,011,375,922.45	2,566,552,065.37

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,959,543,422.45	2,514,187,965.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,227,919,072.45	1,848,493,466.00
210101	Үндсэн цалин	844,673,620.23	1,108,432,266.71
210102	Нэмэгдэл	341,113,782.20	685,435,538.77
210104	Урамшуулал	42,131,670.02	54,625,660.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,455,000.00	242,787,800.00
210201	Тэтгэврийн даатгал	107,069,600.00	165,129,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,596,200.00	19,414,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,076,700.00	9,707,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,519,200.00	9,707,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,193,300.00	38,829,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	452,439,100.00	225,602,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,996,624.00	9,265,748.09
210302	Түлш, халаалт	445,442,476.00	216,336,251.91
2105	Нормативт зардал	82,987,052.00	112,165,800.00
210502	Хоол, хүнс	82,987,052.00	112,165,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,703,100.00	27,980,849.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	753,000.00	4,412,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,950,100.00	23,568,349.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,940,098.00	55,658,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,553,098.00	42,552,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,387,000.00	13,105,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,832,500.00	52,364,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,832,500.00	52,364,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,832,500.00	52,364,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>98,647,125.55</u>	<u>101,013,334.63</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39,089,700.00	51,617,017.13
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,089,700.00	51,617,017.13
2200	Дотоод эх үүсвэрээр	39,089,700.00	51,617,017.13
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,089,700.00	51,617,017.13
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(39,089,700.00)</u>	<u>(51,617,017.13)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	59,557,425.55	49,396,317.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,407,334.00	69,964,759.55
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	69,964,759.55	119,361,077.05

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	679,906,375.91	592,412,405.74	4,896,351,601.56	6,168,670,383.21
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	679,906,375.91	592,412,405.74	4,896,351,601.56	6,168,670,383.21
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,906,375.91	592,412,405.74	4,896,351,601.56	6,168,670,383.21
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	679,906,375.91	592,412,405.74	4,896,351,601.56	6,168,670,383.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	679,906,375.91	592,412,405.74	4,896,351,601.56	6,168,670,383.21
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			284,253,645.79	284,253,645.79

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,132,430,500.00	2,051,771,523.45	2,737,530,000.00	2,618,169,082.50
УРСГАЛ ЗАРДАЛ	2,132,430,500.00	2,051,771,523.45	2,737,530,000.00	2,618,169,082.50
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,074,765,100.00	1,999,939,023.45	2,685,165,900.00	2,565,804,982.50
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,284,868,900.00	1,227,919,121.45	1,969,400,500.00	1,854,518,876.00
Үндсэн цалин	887,889,200.00	852,632,907.72	1,376,007,800.00	1,108,753,676.71
Нэмэгдэл	358,280,300.00	341,017,095.48	580,778,200.00	691,139,538.77
Урамшуулал	38,699,400.00	34,269,118.25	12,614,500.00	54,625,660.52
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,608,500.00	157,455,000.00	246,175,200.00	242,787,800.00
Тэтгэврийн даатгал	109,213,900.00	107,069,700.00	167,399,100.00	165,129,300.00
Тэтгэмжийн даатгал	12,848,700.00	12,596,400.00	19,694,000.00	19,414,600.00
ҮОМШӨ-ний даатгал	10,278,900.00	10,076,600.00	9,847,100.00	9,707,400.00
Ажилгүйдлийн даатгал	2,569,700.00	2,519,100.00	9,847,100.00	9,707,400.00
Эрүүл мэндийн даатгал	25,697,300.00	25,193,200.00	39,387,900.00	38,829,100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	464,769,100.00	452,769,100.00	225,602,000.00	225,602,000.00
Гэрэл, цахилгаан	4,591,000.00	4,591,000.00	4,591,000.00	9,265,748.09
Түлш, халаалт	460,178,100.00	448,178,100.00	221,011,000.00	216,336,251.91
Нормативт зардал	85,801,300.00	84,292,852.00	112,165,800.00	112,165,800.00
Хоол, хүнс	85,801,300.00	84,292,852.00	112,165,800.00	112,165,800.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00	1,500,000.00	1,500,000.00
Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00	1,500,000.00	1,500,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,903,100.00	7,903,100.00	34,152,600.00	34,152,206.50
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	753,000.00	753,000.00	4,412,500.00	4,412,500.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,150,100.00	7,150,100.00	29,740,100.00	29,739,706.50
Бараа үйлчилгээний бусад зардал	69,714,200.00	68,499,850.00	96,169,800.00	95,078,300.00
Бараа үйлчилгээний бусад зардал	58,989,000.00	57,774,650.00	83,064,500.00	81,973,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,725,200.00	10,725,200.00	13,105,300.00	13,105,300.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,665,400.00	51,832,500.00	52,364,100.00	52,364,100.00

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад урсгал шилжүүлэг	57,665,400.00	51,832,500.00	52,364,100.00	52,364,100.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,665,400.00	51,832,500.00	52,364,100.00	52,364,100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,122,023,100.00	2,110,023,100.00	2,667,565,400.00	2,667,565,400.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,654,250,300.00	1,654,250,300.00	2,435,714,900.00	2,435,714,900.00
Улсын төсвөөс санхүүжих	1,654,250,300.00	1,654,250,300.00	2,435,714,900.00	2,435,714,900.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	465,869,100.00	453,869,100.00	227,102,000.00	227,102,000.00
Орон нутгийн төсвөөс	465,869,100.00	453,869,100.00	227,102,000.00	227,102,000.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,903,700.00	1,903,700.00	4,748,500.00	4,748,500.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	753,000.00	753,000.00	4,412,500.00	4,412,500.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,150,700.00	1,150,700.00	336,000.00	336,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		10,407,334.00		69,964,759.55
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		69,964,759.55		119,361,077.05
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00
Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
Төсвөөс гадуур байгууллага				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	81.00	81.00	81.00	81.00
Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
Гүйцэтгэх ажилтан	50.00	50.00	50.00	50.00
Үйлчлэх ажилтан	30.00	30.00	30.00	30.00
Гэрээт ажилтан				
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	443.00	443.00	446.00	446.00
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	443.00	443.00	446.00	446.00
Төрийн өмчит ЕБС	443.00	443.00	446.00	446.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	80.00	80.00	81.00	81.00
СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	49.00	49.00	50.00	50.00
Соёл урлагийн салбарын төрийн ийлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00	1.00	1.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	30.00	30.00	30.00	30.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь бүрэн дунд боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль тайлант оны зорилгыг "Хичээлээ тасалдаггүй, хоцордоггүй, хичээлийн цагаар гар утас хэрэглэдэггүй, өдөр бүр мэндэлдэг хүүхдийг төлөвшүүлнэ" гэж тодорхойлсон байна.

Зорилгыг биелүүлэх хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүн

Зорилт1:Цаг ашиглалтыг сайжруулах

Зорилт2:Мэндлэх, хүндлэх дадал бий болгох

Зорилт3:Бие даан суралцах чадварыг дэмжих

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 онд санхүүгийн үйл ажиллагаанд ямар нэгэн шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2018 оны 11 сарын 02-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 299 дүгээр тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 276.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	69,964.8	119,361.1	49,396.3
Авлага	-	-	-
Бараа материал	57,145.9	99,924.6	42,778.7
Үндсэн хөрөнгө	6,057,032.6	6,241,846.4	184,813.8
Нийт хөрөнгө	6,184,143.3	6,461,132.1	276,988.8
Өр төлбөр	15,472.9	8,208.1	-7,264.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,168,670.4	6,452,924.0	284,253.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,184,143.3	6,461,132.1	276,988.8

Дээрх хүснэгтээс харахад дараах өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 49.3 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 99.9 сая төгрөг болж 42.7 сая төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд 197.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 181.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж оны эцэст 42.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна. Акталсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,452.8 сая төгрөг болж 181.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлт сургуулийн шинэ байр ашиглалтанд орж улсын хөрөнгө оруулалтаар 163.4 сая төгрөгний хөрөнгө үнэ төлбөргүй хүлээж авсан мөн сургуулийн 80 жилийн ойн баяртай холбоотой ард иргэдээс 78.3 сая төгрөгний хөрөнгө хандивлсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 284.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,479.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,479.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж төсвийн төслийн саналаас 47.3 сая төгрөгөөр хасч, 1,431.2 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор анх баталсан төсвийг 11 сард 1,046.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,505.6 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 227.1 сая төгрөгийг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 4,748.5 сая төгрөгийн санхүүжүүлэхээр нийт 2,737.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,435.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 227.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 4.8 сая төгрөгийн орлогыг оруулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,618.2 сая төгрөг буюу 95.6 хувьтай, дансанд 119.3 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
80826	Байр ашиглалтын үйлчилгээ	3,190.0	3,190.0	-	100.00 %
80223	Хүүхэд хамгаалал	3,331.6	3,169.7	161,9	94.29 %
80312	Сургалт семинар	2,274.0	2,274.0	-	100.00 %
81605	Эрүүл мэндийг дэмжих	4,396.5	4,396.5	-	100.00 %
81801	Үдийн цай хөтөлбөр	52,364.1	52,364.1	-	100.00 %
81806	Дотуур байрны үйлчилгээ	461,369.9	461,369.9	-	100.00 %
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	36,874.3	36,874.3	-	100.00 %
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	9,569.9	9,569.9	-	100.00 %

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

81827	Бичиг үсгийн боловсролын хөтлбөр	21,542.7	21,542.7	-	100.00 %
81834	Боловсролын стандарт, сургалтын	1,895,407.0	1,777,152.9	118,254.1	93.76%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	10,188.4	9,243.4	95.4	90.72%
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	336.0	336.0	-	100.00 %
81848	Сурах бичгийн түрээс	4,412.5	4,412.5	-	100.00 %
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	5,170.7	5,170.7	-	100.00 %
88011	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	227,102.0	227,102.0	-	100.00%
	Дүн	2,737,530.0	2,618,169.1	119,360.9	95.64%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй, Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь заалтыг дагаж мөрдөөгүй, цалингийн зардлын данснаас ахмадуудын баяраар 0.9 сая төгрөгний зардал гаргаж хүндэтгэл үзүүлсэн байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

БНАҮТХураамжийн данснаас номын түрээсээс орж ирсэн орлогоос 4.4 сая төгрөгний зардал гарсан байна. Бусад бараа үйлчилгээний бусад данснаас 81.9 сая төгрөгний зардал гарсан үүнээс 36.9 сая төгрөг нь Монголын цахилгааны холбоо компаниас Ерөнхий гэрээгээр худалдан авсан интернет төхөөрөмжийн үнэ байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль нь батлагдсан төсвийн хүрээнд 197.6 сая төгрөгийн бараа материал, 51.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ш.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 10 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,139.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 32.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 22.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,565.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 38.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 27.0 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 11.8 сая төгрөгний 2 гүйлгээ, орлогын 35.1 сая төгрөгний 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 19.7 сая төгрөгийн 10 шийдвэрийг мэдээлээгүй байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 90.2 хувьтай байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2024 онд завсарын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 4 төрлийн зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	364,541.2	4	364,541.2	100%
Нийт дүн	4	364,541.2	4	364,541.2	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар аж ахуйн материалын тооллогын баримтжуулалтад анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар 159.9 сая төгрөгийн зөрчил илэрч 34.9 сая төгрөгийн албан шаардлага, 125.0 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 34.9 сая төгрөгийн зөрчилд¹ 1 албан шаардлага хүргүүлэв.

1. Сургуулийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн Б/38 дугаартай нэмэгдэл хөлс олгох тухай тушаалаар ажилтнуудад 34.9 сая төгрөгний илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосон байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5-д “*Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэжүүлнэ*”, 16.5.5-т “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна*.”

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн нэмэгдэл хөлсийг холбогдох хууль, журмыг баримталж олгож байхыг албан шаардлага болгов.

5.3 Зөвлөмж

Аудитаар нийт 125.0 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын тооллоготой холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Сургуулийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/35 дугаар тушаалаар байгуулсан жилийн эцсийн тооллого хийх комисс тооллого хийхдээ 53.9 сая төгрөгний аж ахуйн материалын тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2- “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Жилийн эцсийн тооллогыг иж бүрэн, үнэн зөв хийж тооллогын бэртгэлийг баримтжуулах, хяналтыг сайжруулах;

2. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 38.1 сая төгрөгийн орлогын 1 мөнгөн гүйлгээг, 11.8 сая төгрөгний зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 19.7 сая төгрөгийн 10 шийдвэрийг мэдээлээгүй байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5 дугаар зүйлийн 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 38.1 сая төгрөгийн орлогын 1 мөнгөн гүйлгээг, 11.8 сая төгрөгний зарлагын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 19.7 сая төгрөгийн 10 шийдвэрийг шилэн дансанд нөхөж оруулан зөрчлийг арилгах;

3. Иргэдээс хандиваар олгосон хөрөнгийн бүртгэлийг холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Сургуулийн захирлын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/45 дугаар тушаалаар сургуулийн 80 жилийн ойгоор ард иргэдээс өгсөн 81.4 сая төгрөгний хандивын хөрөнгийг орлого авах шийдвэр гаргаснаас 80.0 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч, 1.4 сая төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Иргэдээс хандиваар олгосон 1.4 сая төгрөгийн хөрөнгийг 39215 дансанд орлого авч бүртгэлд тусгах;

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /дотуур байрны хоол хүнс 112.1 сая төгрөг, үдийн хоол 52.3 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

Буянт сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Алба н туша алтн ы тоо	Тоо	Дүн
Цалин хөлстэй холбоотой	1	34,931.7	0	0	1	34,931.7	0	0				
Бараа материалын тооллоготой холбоотой	1	53,935.4	0	0	0	0	1	53,935.4				
Хандивтай холбоотой асуудал	1	1,440.0	0	0	0	0	1	1,580.1				
Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой	1	69,636.8	0	0	0	0	1	69,636.8				
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй	1						1					
Дүн	5	159,943.9	0	0	1	34,931.7	4	125,012.2				